

**2021 ОНЫ 07 ДУГААР САРЫН 05-НЫ ӨДРИЙН ШУУРХАЙ  
ХУРЛААС ӨГСӨН ҮҮРГИЙН ХЭРЭГЖИЛТ**

2021.07.19

№	Үүрэг даалгавар	Хариуцах хэлтэс	Хэрэгжилт
1	Төрийн байгууллагуудыг 10 хувиар ажиллуулах тухай чиглэл амралтын өдөр ирсэн. Энэ бичгийг олж үзээд яаралтай чиглэл өгөх шаардлагатай бол энэ чиглэлүүдийг нь хэлтэс, агентлагуудад өгөх.	ТЗУХ	Хэлтэс, агентлагуудад холбогдох чиглэлийг хүргүүлсэн.
2	Таны ярьсан батламж гардуулах ажлын хүрээнд батламж хэвлэгдээд ирчихвэл гардуулах хувиараа гаргаад маш яаралтай хийхгүй бол 50 байгууллагаар явах хэрэг гарах нээ. ИТХурлын ажлын албатай яриад хамтарч зохион байгуулах ажлаа яаралтай зохион байгуул.	ТЗУХ	Хуваарь гаргаж ЗДТГ-ын даргаар батлуулан ЗДТГ-ын хэлтсүүдэд хуваарилж талархлыг байгууллагуудад гардуулж өгсөн.
3	Баяр наадмын хариуцлагатай жижүүр томилох тухай хуваарийг яаралтай гаргаж батлуулж мэдээллийг хүргэх	ЗАА	Аймгийн Засаг даргын 2021.07.08-ны өдрийн 01-А/205 дугаар захирамжаар аймгийн хариуцлагатай жижүүрийн хуваарийг батлуулан мэдээллийг хүргүүлсэн.
4	“Ногоон Дархан” дэд хөтөлбөртэй холбоотой хуваарилалтуудаа хийх, НААҮГ-аас оруулсан саналд нь байгаа ажлууд хийгдэхгүй орхигдоод байна. Жишээ нь: зам дагуу ил байршлууд дээр хийгдэхгүй байна. Ил газар хийгдэхгүй байхад орон сууцны хороолол доторх ажлууд хийгдэхгүй байгаа нь ойлгомжтой байх. Энэ ажлуудаа анхаарч хийхгүй бол орхигдоод байна. Хар шороогоо татах, хуваарилж өгөх гэх мэт.	ЗАА	<ul style="list-style-type: none"> <li>- Дархан сум 9,10,11,12 –р баг төв авто замын тусгаарлах зурвасын тохижилт ногоон байгууламжийн ажил 3 сая төгрөгийн төсөвтэй. Энэ ажлыг 100% гүйцэтгэсэн</li> <li>- Дархан сум 9,10-р баг 2017 оны тохижилт ногоон байгууламжийн ажлын нөхөн сэргээх ажлын хүрээнд 50 ширхэг гүйлс буйлс мод, 60 ширхэг голт бор мод тарьж, зүлэг талбайн нөхөн сэргээлт арчилгаа үйлчилгээг 100% хийж гүйцэтгэсэн</li> <li>- 3,5 га талбайд хийгдэх ажил хаврын тарилтын хугацаанд 100% хийж гүйцэтгэсэн</li> <li>- Морин хуур цоцголборын тохижилт ногоон байгууламжийн ажлын тендерийн материал хүлээгдэж байна.</li> </ul> <p>6 цогц ажлыг гүйцэтгэхээр төлөвлөгдсөнөөс 7 сарын 5-ны байдлаар 4 ажлыг 100% гүйцэтгэж дууссан байна.</p>
5	“Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжийн устгал хийгдээд дууссан гэсэн энэ нь байгаад л байна.	ЗАА	Шарилжгүй Дархан” дэд хөтөлбөрийн 1 дүгээр шатны ажлыг

	Бороо их орж байгаатай холбоотой их ургасан байж болно. Гэхдээ орон сууцны хороолол дотор зөндөө шарилж байна.		НААҮГ 141 га талбайд 22 хүний бүрэлдэхүүнтэйгээр 100% хийж гүйцэтгэсэн. Үүнээс гадна Цагдаагийн газрын Cannabis sativa L устгалын ажилд 10 ажилчин агрономчийн хамт 5 өдөр ажилласан. СӨХ-д 16 га газрын шарилж устгаж байна.
6	Нийтийн цэвэрлэгээний ажлыг Ковидын үед орхигдуулахгүй хийж явах, хэвшүүлэх, иргэдэд сурталчилах, мэдээлэх чиглэлээр Мэдээлэл технологийн алба ОНӨААТҮГ-тай хамтран ажил зохион байгуулах	ЗАА, МТА	Сар бүрийн эхний 7 хоногийн бямба гарагт бүх нийтийн их цэвэрлэгээний ажлыг зохион байгуулах тухай аймгийн Засаг даргын 2021 оны 01-А/128 тоот захирамжийн хүрээнд Төрийн болон ААНБ, СӨХ-уудад бүх нийтийн цэвэрлэгээний талаарх мэдээ, мэдээлэл хүргэх ажлыг Мэдээлэл технологийн албатай хамтран зохион байгуулан ажилласан.
7	Хорооллын доторх болон авто зам дагуух гэрэлтүүлгийн ажлыг НААҮГ-тай хамтраад анхаарах шаардлагатай байна. Унтарсан, шатсан зэрэг асуудлууд дээр хяналт тавьж гэрэл гэгээтэй байлгах шаардлагатай байна.	ЗАА	Дархан хотын гэрэлтүүлэгийн ашиглалт хамгаалалт хэвийн ажиллаж байгаа.
8	Аймгийн Онцгой комиссын шийдвэрээр Дарханаас орох гарах хөдөлгөөнийг хязгаарласан. Тэгэхээр Дарханы иргэд энэ олон амралтын өдрүүдэд Дархандаа байна гэж ойлгож байна. Энэ хүмүүс амралтын өдрүүдэд голын эрэг, Зулзагын гол, Салхитын амралтын бүс орчимд амрах байх. Өнгөрсөн амралтын өдрүүдэд хүүхдийн зуслантай холбоотой Зулзагын голд ажилласан. Тэнд залуучууд архи согтууруулах ундаа хэтрүүлэн хэрэглэсэн байдалтай автомашин бариад явж байна. Миний анзаарснаар тэнд эрсдэл маш их байна. Энэ асуудал дээр Цагдаагийн газар 9 хоногийн хугацаанд анхаарал хандуулж гэмт хэрэг, зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх, хяналтыг сайжруулахгүй бол асуудал үүсч магадгүй байна. Үүнийг анхааралдаа ав.	ХЭЗХ	Зулзагын гол орчимд 1 цагдаа байнга буюу 24 цагаар, Хараа голын эргээр өдөр бүр морин эргүүл 2, Замын цагдаагийн тасгаас 2 цагдаа автомашинтай 10-23 цагийн хооронд эргүүлээр ажиллаж байна.
9	Цахим бар ХХК улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хороолол доторх зам засварын ажил хийгдэж байна. Үүнтэй холбоотой нэмэлт гэрээ байгуулаад 9-р багт засвар шинэчлэлийн ажил хийх явцад цахилгааны кабель таарсан. Энийг шилжүүлэх материалын зардал нь 20 сая төгрөг болсон. Аймгийн Засаг дарга, Хотын захирагчийн орлогч Б.Батболд бид гурав ярьж тохиролцсоны үндсэн дээр 10 сая төгрөгөөр хийе гээд шийдсэн. Энэ 10 сая төгрөгийг шийдээд гаргая гээд эх үүсвэр нь тодорхой болоод гэрээ нь байгуулагдсан.	ХОХБТХ	2021 оны 07-р сарын 05-ны өдөр “ДСЦТС” ХК-д санхүүжилтийг шилжүүлсэн болно.

	Цахилгаан түгээх станц мөнгөө орж ирвэл материалаа авч ажлаа хийж дууссаны дараа, дараагийн зам засвар, зогсоолын ажил хийгдэх ёстой. Энэ асуудал танай хэлтэс дээр очоод гацсан. Энэ асуудлыг яаралтай шийдвэрлэ.		
10	ИТХ-аар хэлэлцээд төсвийн зохицуулалт хийгдээд замын уулзвар засвар дээр 100 сая төгрөг тавигдсан. Энэ олон хоногийн амралтын хугацаанд уулзвар засварын ажлыг эхлүүлмээр байна.	ХОХБТХ	“Дархан-АЗЗА” ТӨХК-тай гэрээ байгуулахаар санал хүргүүлсэн. “Дархан-АЗЗА” ТӨХК нь судалж үзэхээр болсон. Хариу ирүүлээгүй байна.

### ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС